

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.03.17**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- S&P 500 Index, Nasdaq Composite, Russell 2000 Index дөрөв дэх долоо хоногтоо дараалан сөрөг үзүүлэлттэй гарсан бол S&P MidCap 400 Index долоо дахь долоо хоногтоо тасралтгүй буурлаа.
- Суурь CPI (хүнс, эрчим хүчний үнээс хассан) жилийн дүнгээр 3.1%-иар өссөн нь 2021 оны 4-р сараас хойших хамгийн бага өсөлт байв.
- Төв банкны бодлого тодорхойлогчид 3-р сарын 18–19-ний хуралдаанаар бодлогын хүүг өөрчлөхгүй үлдээнэ гэсэн хүлээлт өндөр байна.
- Хэрэглээний сэргэлт нь Хятадын эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл байх тул эрх баригчид шинэ бодлого танилцуулах нь олон нийтийн анхаарлын төвд байна.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.03.10-03.16

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ УНАСААР...

АНУ-ын хувьцааны зах зээл өнгөрсөн долоо хоногт дахин нэг уналттай долоо хоногийг үдлээ. S&P 500 Index, Nasdaq Composite, Russell 2000 Index дөрөв дэх долоо хоногтоо дараалан сөрөг үзүүлэлттэй гарсан бол S&P MidCap 400 Index долоо дахь долоо хоногтоо тасралтгүй буурлаа. Dow Jones Industrial Average 3.07%-иар унаж, таван индекс бүгд оны эхний үзүүлэлтээс доогуур түвшинд хүрэв.

Худалдааны бодлоготой холбоотой тодорхойгүй байдал нь зах зээлд сөрөг хандлага давамгайлахад голлох хүчин зүйл болсон бөгөөд Трампын засгаас шинэ тарифын шийдвэрүүдийг долоо хоног бүр зарлаж байгаа нь үүнд нөлөөлөв. Мөн эдийн засгийн өсөлтийн удаашрал, хямралын эрсдэл нэмэгдэж, Ерөнхийлөгч Дональд Трамп “АНУ шилжилтийн үед орж байна” гэсэн мэдэгдэл нь эдгээр айдсыг улам хүчтэй болгож, зах зээлийн уналтад нөлөөлсөн байна.

### ҮНИЙН ӨСӨЛТ ХОЁРДУГААР САРД СААРАВ

Өнгөрөгч долоо хоногийн эдийн засгийн голлох мэдээлэл нь Лхагва гарагт Хөдөлмөрийн яамнаас танилцуулсан Хэрэглээний үнийн индекс (CPI) байсан бөгөөд тус индекс хоёрдугаар сард 0.2%-иар өссөн. Харин суурь CPI (хүнс, эрчим хүчний үнээс хассан) жилийн дүнгээр 3.1%-иар өссөн нь 2021 оны 4-р сараас хойших хамгийн бага өсөлт байв. CPI-ийн өсөлт нэгдүгээр сараас удааширсан бөгөөд шинжээчдийн таамгаас бага гарсан нь инфляц буурч байгаа нааштай дохио болов. Энэ нь АНУ-ын эдийн засаг стагфляцын эрсдэлд орж болзошгүй гэсэн болгоомжлолыг хэсэг ч болов намжаалаа. Трампын засгийн саяхан зарласан тарифуудын нөлөө бүрэн илрээгүй тул инфляц үргэлжлүүлэн буурахад эргэлзээтэй.

Пүрэв гарагийн Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) мөн инфляц саарсныг харуулав. PPI нь хоёрдугаар сард өмнөх сараас өөрчлөлтгүй байсан бол суурь PPI анх удаа долдугаар сараас хойш буурсан. Энэ нь шинжээчдийн 0.3%-иар өсөх таамгаас доогуур гарсан эерэг үр дүн байв. Гэсэн хэдий ч Хувийн хэрэглээний зарлагын индекс (PCE) буюу Холбооны Нөөцийн Сангийн голчлон ажигладаг инфляцын үзүүлэлт өндөр хэвээр үлдэх магадлалтай байна. PCE-ийг энэ сарын сүүлчээр зарлах бөгөөд ХНС-гийн зорилтот 2%-ийн түвшнээс дээгүүр хэвээр байх төлөвтэй байна. Үүний улмаас төв банкны бодлого тодорхойлогчид 3-р сарын 18-19-ний хуралдаанаар бодлогын хүүг өөрчлөхгүй үлдээнэ гэсэн хүлээлт өндөр байна.

Хэрэглэгчдийн итгэлийн индекс гурав дахь сардаа дараалан буурчээ. Баасан гарагт Мичиганы Их Сургуулиас гаргасан Иргэдийн итгэлийн индекс сарын дүнгээр 11%-иар буурч 57.9 боллоо. Тайланд дурдсанаар, хувийн санхүү, хөдөлмөрийн зах зээл, инфляц, бизнесийн нөхцөл, хөрөнгийн зах зээл зэрэг олон чиглэлд иргэдийн хүлээлт муудсан нь голчлон эдийн засгийн бодлоготой холбоотой тодорхойгүй байдал юм. Түүнчлэн нэг жилийн инфляцын хүлээлт 4.3%-иас 4.9% болж өссөн нь 2022 оны 11-р сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд гурав дахь сардаа дараалан 0.5 пункт буюу түүнээс их хувиар өссөн байна. Эдгээр үзүүлэлтүүд нь эдийн засагт инфляцын дарамт зарим талаар буурч буй ч цаашдын үнэ өсөлт, хэрэглэгчдийн хүлээлт, бодлогын тодорхойгүй байдал хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд хэвээр байгааг харуулж байна.



## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.03.10-03.16

### ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ӨСӨХ ХҮЛЭЭЛТ НЭМЭГДЭВ

Бээжин даваа гарагт хэрэглээг дэмжих бодлого танилцуулах хэвлэлийн бага хурал хийхээ зарласны дараа эх газрын Хятадын хөрөнгийн зах зээл өсөлт үзүүллээ. CSI 300 индекс 1.59%-иар өсөж, Шанхайн нийлмэл индекс 1.39%-иар нэмэгдсэн гэж FactSet мэдээлэв. Харин Хонгконгийн Hang Seng индекс 1.06%-иар буурав.

Төрийн зөвлөлийн мэдэгдлээр, БНХАУ-ын Сангийн яам, Худалдааны яам, Төв банк, Санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагуудын албан тушаалтнууд уг хуралд оролцож, хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг танилцуулах гэж байгаа нь тодорхой болсон. Уг мэдээ Баасан гарагт Хятадын хувьцааны үнийг огцом өсгөж, CSI 300 индексийг 12-р сарын дундаас хойших хамгийн өндөр түвшинд хүргэлээ.

### ХЭРЭГЛЭЭ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТҮЛХҮҮР БОЛЖ БАЙНА

АНУ-аас үүдэлтэй худалдааны дайнаас хойш эдийн засгийн өсөлтийг хэрэглээг нэмэгдүүлэх замаар дэмжих нь Хятадын бодлого тодорхойлогчдын тэргүүлэх чиглэл болжээ. Үндэсний Ардын Их Хурал саяхан хуралдаж, Хятад улс гурав дахь жилдээ 5%-ийн эдийн засгийн өсөлтийн зорилт дэвшүүлж, 2025 онд хэрэглээг нэмэгдүүлэхийг тэргүүлэх зорилт болгосон байна.

Гэвч дотоодын сул хэрэглээ нь Хятадын хамгийн сүүлийн инфляцын тайлангаас тодорхой харагдаж байна. Үндэсний статистикийн товчооны мэдээлснээр, хэрэглээний үнийн индекс (CPI) хоёрдугаар сард жилийн дүнгээр 0.7%-иар буурсан нь 2024 оны 1-р сараас хойших анхны уналт болов.

Харин суурь CPI (хүнс, эрчим хүчний үнийг хассан) 0.1%-иар буурсан нь 2021 оноос хойших анхны уналт бөгөөд 15 жилийн хугацаанд ердөө хоёр дахь удаагаа буурч буй тохиолдол гэж Bloomberg мэдээлэв. Үүний зэрэгцээ, бөөний үнийг илэрхийлдэг үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) хоёрдугаар сард 2.2%-иар унаж, 29 дэх сардаа дараалан буурсан байна.

### ДЕФЛЯЦИТАЙ ТЭМЦЭХ ЯАРАЛТАЙ АРГА ХЭМЖЭЭ

Хятадын эрх баригчид дефляцийн эрсдэлтэй тулгараад байна. Бээжин өнгөрсөн есдүгээр сараас эхлэн мөнгөний болон төсвийн хэд хэдэн урамшууллын бодлого хэрэгжүүлсэн боловч орон сууцны зах зээлийн олон жилийн уналт иргэдийг мөнгөө хадгалах хандлагатай болгосон тул хэрэглээг дэмжих зорилтууд үр дүн багатай байгаа аж.

Хэрэглээний сэргэлт нь Хятадын эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл байх тул эрх баригчид шинэ бодлого танилцуулах нь олон нийтийн анхаарлын төвд байна.



## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
March 10, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
BNTX	ORCL	KSS	SMST	ZIM	ADBE	QTS	DOCU	LI	理想
BIONTECH	ORACLE	KOHL'S	SMITH MICRO SOFTWARE	ARCO	Adobe	D:WAVE	DocuSign	BTBT	理想
FNVI	ASAN	DICK'S SPORTING GOODS	HERITAGE INSURANCE	Arcos Dorados	PATH	DG	ULTA BEAUTY	GOGO	BIT DIGITAL
Franco-Nevada	asana	VIKING	MaxCyte	IRBT	UiPath	WB	MNR	GOGO	gogo
NPWR	Paymentus	UNFI	STITCH FIX	Robot	S	新浪微博 weibo.com	MACH	WRD	WRD
NETPOWER	FlOTEK	AVINO	ASHI	MX	PHR	CION	Generation	WOW	WOW!
FENC	MTN	GRPN	VTS	Magnachip	CCI	FUTU	SEMTECH	AIRS	AirSculpt
FENNEC PHARMA	VAIL RESORTS	Casey's	Vitesse	AMRN	CROWN CASTLE	SOHO	KINS	HUDSON	Hudson
DARO	HSAI	FERGUSON	GROUPOIN	AMRN	AED	BLDP	KINGSTONE	DRILLING TOOLS	DRILLING TOOLS
ALIGOS	HESAI	BrainWay	Casey's	CKM	AMERICAN EAGLE OUTFITTERS	WORKSHOP	PORTMAN	blink	blink
URGNI	AUNA	FUEL CELL ENERGY	Bowman	ONDS	AEYE	RCM	PORTMAN	emeren	emeren
UroGen Pharma	auna	LEGEND BIOTECH	FOA	ONDAS	audioeye	BALLARD	PORTMAN	emeren	emeren
TLS	GAIA	LEGEND BIOTECH	FOA	MOMO	ECOR	WORKSHOP	PORTMAN	emeren	emeren
Telos	GAIA	LEGEND BIOTECH	FOA	WOH	TYLS	RCM Technologies	PORTMAN	emeren	emeren
	LFMD			CDLX	cardlytics	uCloudlink			
	LifeMD+								
	LCTX								
	LINEAGE CELL THERAPEUTICS								
	http://eps.sh/cal								

© 2025 Earnings Whispers

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
March 17, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
QFIN	HRTI	SNCL	STNE	SIG	FIVE	POD	MU	NIO	NIO
360金融	HIGHTIDE FGEN	SUNDIAL XPEV	stone	SIGNET JEWELLERS	five BEP W	Pinduoduo Inc. 拼多多	Micron	CCL	CARNIVAL CORPORATION & PLC
PLX	FibroGen	X P E N G	maravai	WISM	FVR	ASO	NKE	MINI	MINI
PROTALIX Biotherapeutics	OpenLending	BITCOIN DEPOT	HealthEquity	WILLIAMS-SONOMA	FRONTVIEW REIT	Academy Sports and Outdoors	FOX	SCWG	SCWG
TSQ	SAIC	huya	waldencast	OLLIE'S GOOD STORY CHEF	NOA	JABIL	FedEx	SEW GOOD	SEW GOOD
townsquare	SAIC	huya	waldencast	General Mills	WS	DARDEN RESTAURANTS	LENNAR		
INSE	HROW	ESLT	ZTO 中通快递	Kingsoft Cloud	WORTHINGTON STEEL	ACN	planet.		
INSPIRED	HARROW	Elbit Systems	ZTO 中通快递	SRAD	YY	accenture	planet.		
DIVERSIFIED energy	NGS	BEKE	SURFAIR MOBILITY	spetradar	MSF	LANDS' END	KINDER CARE		
SHOE	INDUSTRIES	ETON	INOVO	TCHY	GROY	GAMB	AMPRIUS		
SONIDA SENIOR LIVING QTRH	INDUSTRIES	PHARMACEUTICALS	absci	Tencent 腾讯	GoldRoyalty	gambing.com	amprus		
QUARTERHILL	Lithium Argentina	TENCENT MUSIC ENTERTAINMENT	OmniAb	ILL	AEVA	FACTSET	VAXART		
	GETY	CONSOLIDATED WATER		MDWD	AEVA CAPR	SHOE CARNIVAL	SCHL		
	gettyimages	IHS		NEON	Capricor	Adaptimmune	TORRID		
	HNRG			neonode			SIZES 10 TO 30		
	http://eps.sh/cal								

© 2025 Earnings Whispers